

ХайБиОйл Хувьцаат Компани

Нэмэлт санхүүжилт татах

Танилцуулга



Монгол Улс,
Улаанбаатар хот,
Сонгино Хайрхан дүүрэг,
20 дугаар хороо
“ХайБиОйл” ХК

ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА НЬ МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД ӨГСӨН МАТЕРИАЛЫН БҮРЭН ХУУЛБАР БӨГӨӨД ТАНИЛЦУУЛГАД ОРСОН МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВИЙГ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ БОЛОН АНДЕРРАЙТЕР ТАЛ ХАМТРАН ХҮЛЭЭНЭ.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН “КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ”, “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ” БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ ӨӨРИЙН ДҮРМИЙН САНГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙГАА БОЛНО.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ НИЙТЭД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХААР ГАРГАЖ БУЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.



**Ерөнхий зуучлан борлуулагч:
Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
“БиДиСЕК” Хувьцаат Компани
Андеррайтер, Брокер, Дилер,
Хөрөнгө Оруулалтын Зөвлөх
www.bdsec.mn**

**Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Залуучуудын өргөн чөлөө 27/1, “БиДиСЕК” ХК-ний байр**

ГАРЧИГ**Хуудас**

1.	Нэмэлт хувьцааны товч танилцуулга	4
2.	Ажилласан тос цэвэршүүлэх төслийн товч танилцуулга	5
3.	Компанийн танилцуулга	6
4.	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	10
5.	Нэмэлт санхүүжилт	12
6.	Төслийн өнөөгийн байдал	15
7.	Эдийн засгийн тооцоо	16
8.	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	18
9.	Эрсдэл	19
10.	Хувьцаа хэрхэн худалдан авах	22
11.	Андеррайтерийн танилцуулга	23
12.	Хавсралт	
	Андеррайтерийн дүгнэлт	24
	Сүүлийн 3 жилийн санхүүгийн аудитлагдсан тайлан	30
	2009 оны 11 сарын 17-ны ХНХ-ийн тогтоол 1, 2	50
	2010 оны 3 сарын 18-ны ТУЗ-ийн хурлын тогтоол 1	52
	2010 оны 9 сарын 2-ны ТУЗ-ийн хурлын тогтоол 1, 2	53
	“ХайБиОйл” ХК, “БиДиСЕК” ХК-ийн хамтын ажиллагааны гэрээ	55

НЭМЭЛТ ХУВЬЦААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн нэр:	“ХайБиОйл” ХК
Хувьцааны код:	НВО/525/
Хувьцааны төрөл:	Энгийн, биет бус
Хаяг:	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 барилга, 405 тоот
Нийт хувьцааны тоо:	7,000,000 ширхэг
Нэрлэсэн үнэ:	100 төгрөг
Нэмж татах санхүүжилтийн хэмжээ:	388,762,550 төгрөг
Нэмэлт хувьцааны нэг бүрийн худалдах үнэ:	174 төгрөг
Нэмэлт хувьцааны тоо ширхэг:	2,234,268 ширхэг
Зээлийн гэрээний дагуу хувьцаанд хөрвөх тоо:	1,663,910 ширхэг
Олон нийтэд санал болгож буй тоо:	570,358 ширхэг
Нэмэлт санхүүжилт татах нөхцөл:	Нийт гаргаж буй 2,234,268 ширхэг хувьцааны 74,47 хувь нь зээлийн гэрээний дагуу хувьцаанд хөрвөж, үлдэх 25,53 хувь нь олон нийтэд санал болгогдоно.
2009 оны 10 сарын 6-ны байдлаар хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид компанийн тухай хуулийн 39-р заалтын дагуу давуу эрхээр:	Өөрийн эзэмшиж буй хувьцааны 31,92 хувьтай тэнцэх хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
Андеррайтер:	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө Оруулалтын Зөвлөх “БиДиСЕК” ХК
Хаяг:	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 тоот барилга
Утас, факс:	976-11-313108, 976-99012444
Цахим хуудас:	www.bdsec.mn
И-майл хаяг:	tsog@bdsec.mn , info@bdsec.mn

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- | | |
|-----------------------------------|---|
| 1. Төслийн нэр | Ажилласан тос боловсруулах |
| 2. Төслийн зорилго | Монгол Улсын импортоор авч буй тос, тосолгооны материалыг дотооддоо үйлдвэрлэж, эдийн засгийн өндөр үр өгөөж бүхий байгаль орчинд ээлтэй дотоодын тэргүүлэх ногоон үйлдвэр болох |
| 3. Бүтээгдэхүүн | Суурь тос / <i>Моторын тосны түүхий эд</i> /
Үйлдвэрийн тос / <i>Үйлдвэрлэлд</i> /
Гидрийн шингэн / <i>Тоног төхөөрөмжинд</i> /
Мазут / <i>Шаталтыг дэмждэг</i> / |
| 4. Үйлдвэрийн хүчин чадал | Жилд 2400 тонн тос цэвэршүүлэх |
| 5. Түүхий эд | Техникийн ажилласан тос |
| 6. Төсөл эхэлсэн огноо | 2007 оны 4 дүгээр сар |
| 7. Төсөл хэрэгжих үндэслэл | Монгол улс жилдээ 10'000 орчим тонн тос, тосолгооны материалыг 100 хувийн импортоор авч ашиглаж байна. Тос, тосолгооны материалыг хэрэглэсний дараа ажилласан тосны 20-30% буюу 2'000-3'000 тонн орчмыг буцааж ахуйн хэрэглээ болон барилгын хийц эдлэлийн үйлдвэрийн хэв тосолгоонд хэрэглэдэг бол үлдэх 70-80%-ийг байгальд шууд хаяж байгаль орчныг асар ихээр бохирдуулж байна. Төсөл хэрэгжиснээр зах зээл дээрх нийт хаягдал тосны 25-аас багагүй хувийн боловсруулан цэвэр тосны бүтээгдэхүүний зах зээлийн 16%-аас багагүйг дотооддоо хангах боломжтой. |
| 8. Төсөл хэрэгжих газар | Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан Дүүрэг, 20 хорооны нутаг дэсвгэр дахь 0,8 га үйлдвэрлэлийн зориулалттай газар |

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

“ХайБиОйл” ХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2007 оны 04-р сарын 19-ны өдрийн 41 тоот тогтоол, 2007 оны 11 сарын 29-ны 182 тоот тогтоолын дагуу олон нийтэд нээлттэй Хувьцаат Компани болсон ба нийт 7,000,000 ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээлд гаргаж нийт 1,1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Энэхүү хөрөнгөөр Монголд анх удаа техникийн ажилласан тосыг цэвэршүүлэн эдийн засгийн эргэлтэнд оруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэр байгуулахаар Хонг Конгийн DUNWELL GROUP.,LTD компанийн 1 сард 200 тонн ажилласан тос боловсруулах хүчин чадалтай VSEP технологийн V-MAT I-36 системийн ажилласан тос цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг Сонгино хайрхан дүүргийн 20 дугаар хороонд байрлах өөрийн үйлдвэрийн талбайд 2008 оны 9 сард бүрэн угсарч дууссан. 2008 оны 10 сараас үйлдвэрлэлийг бүрэн ажиллагаанд оруулсан боловч 1 сарын хугацаанд ажиллаад эрчим хүчний таслалтаас үүдэн үйлдвэрийн гол дамжлага болох мембаран шүүлтүүр VMAT I-36 нь бохирдож үйлдвэр хэвийн ажиллах боломжгүй болсон байсан.

Энэ ажилласан хугацаанд бид 20 тонн тос цэвэршүүлэн үйлдвэрлэсэн ба уг тосийг өөрийн гэсэн хэрэглэгчтэй болох, тэдний сэтгэл зүйн эргэлзээг арилгах зорилгоор бүтээгдэхүүнээ хэрэглүүлсэний үр дүнд зарим компаниуд худалдан авах саналаа илэрхийлээд байна.

Удирдлагын танилцуулга



Гүйцэтгэх Захирал, ТУЗ-ийн гишүүн Ө.Хүдрээ

- 1997 онд МУШУТИС-ийг нефтийн инженерийн ангийг төгссөн Нефтийн Инженер мэргэжилтэй
- 1997-2000 онд Шунхлай ХХК
- 2000 оноос хойш “ХайБиОйл” ХК-ийг үүсгэн байгуулсан



Дэд Захирал Б.Мөнхдорж

- 1997 онд МУШУТИС-ийг нефтийн инженерийн ангийг төгссөн Нефтийн Инженер мэргэжилтэй
- 1997-2000 онд Содмонгол ХХК
- 2000 оноос хойш “ХайБиОйл” ХК-ийг үүсгэн байгуулсан


Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд

“ХайБиОйл” ХК нь жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгодог ба 2010 оны 4 сарын 23-ны хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас 04/06 тоот тогтоол гаран дараах гишүүд сонгогдсон.

1. Бүрэнмэнд Лхагвадорж: ТУЗ-ийн дарга
2. Өлзийсайхан Хүдрээ: Гүйцэтгэх Захирал
3. Цэрэнрааш Хангай: ТУЗ-ийн гишүүн
4. Б.Касимов: ТУЗ-ийн гишүүн
5. Досберген Мусаев: ТУЗ-ийн гишүүн
6. Марат Утегенов: ТУЗ-ийн гишүүн
7. Данзан Даянбилгүүн: ТУЗ-ийн гишүүн
8. Нарангэрэл Батгэрэл: ТУЗ-ийн гишүүн
9. Сүх Пүрэвсүрэн: ТУЗ-ийн гишүүн

Бүтэц зохион байгуулалт

Компанийн бүтэц зохион байгуулалтын хувьд дараах схемийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.



Үйл ажиллагааны танилцуулга

“ХайБиОйл” ХК нь өнөөдрийн байдлаар нийт 8 ажилчинтайгаар Хонг Конгийн Данвелль компанийн үйлдвэрлэсэн VSEP технологийн VMAT I-36 системийн ажилласан тос цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг ашиглан өөрийн орны уул уурхай

болон бусад салбарын техник тоног төхөөрөмжнөөс гарч буй хаягдал тосыг дахин боловсруулж эдийн засгийн эргэлтэнд оруулж байна.

Бид өөрсдийн бүтээгдэхүүний түүхий эдийг авто машины тос солих цэгүүд, уул уурхайн компаниуд, газар тариалангийн компаниуд зэргээс хямд үнээр худалдан авч түүнийг боловсруулан Монгол улсын чанарын шаардлагад нийцсэн M-100 маркийн мазут түлш, И-20-ийн төрлийн гидрийн шингэн, үйлдвэрийн тос, суурь тос зэрэг бүтээгдэхүүнүүдийг зах зээлд гаргаж байна.

Бидний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь олон улсад итгэмжлэгдсэн “Амбер” лабораториор баталгаажин гарч байна.

Технологи

DUNWELL GROUP LTD-гийн VSEP технологийн VMAT I-36 системийн төхөөрөмж ашиглаж байгаа ба энэ төхөөрөмж нь тос боловсруулах салбарын хамгийн сүүлийн үеийн байгаль орчинд хор хөнөөлгүй техник юм. Энэ үйлдвэр нь Монгол улсад анхдагч үйлдвэр болж байгаа бөгөөд яг энэ загварын үйлдвэрүүд Хятад, Индонез, Хонг Конгод амжилттай үйл ажиллагаагаа явуулж АНУ болон Европын холбоо, БНХАУ, ОХУ-ын стандартад нийцсэн бүтээгдэхүүн гаргаж байна. [/www.dunwellgroup.com/](http://www.dunwellgroup.com/)

Технологийн давуу тал:

- Дэлхийн байгаль орчин болон тос тосолгооны материалын боловсруулах салбарт 2005 онд шилдэг тоног төхөөрөмжийн шагнал, 2006 онд Байгаль орчныг хамгаалах “INNOVATION” гран при шагнал хүртэж дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн брэнд технологи болсон.
- Уг технологийн дагуу баригдсан ажилласан тос боловсруулах үйлдвэрүүд Хонконгоос гадна Хятад, Индонез зэрэг олон газарт үр ашигтай ажиллаж байгаа.
- Технологийг нийлүүлэгч тал үйлдвэрийг зөвхөн нийлүүлээд зогсохгүй үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд интернэтээр байнга хяналт тавьж, зөвөлгөө өгч, хамтран ажиллана.

Хүчин чадал:

Сард цэвэршүүлэх хэмжээ:	200 тонн
Жилд цэвэршүүлэх хэмжээ:	2400 тонн
Бүтээгдэхүүнийн гарц:	50%

Үйлдвэрлэх бүтээгдэхүүн:

- | | |
|-------------------|--------------------------------|
| - Суурь тос: | Моторын тосны үндсэн түүхий эд |
| - Үйлдвэрийн тос: | Үйлдвэрлэлийн техникүүдэд |
| - Гидрийн шингэн: | Гидр хүчлүүрт техникүүдэд |
| - Мазут: | Шаталтыг дэмждэг |

Бусадтай байгуулсан томоохон гэрээ хэлцлүүд

<p>“DUNWELL GROUP.,LTD” компанитай 2007 оны 8 сарын 28-ны өдөр байгуулсан тоног төхөөрөмж худалдан авах гэрээ</p>	<p>Энэхүү гэрээгээр нийт 560,000 ам.долларийн үнэ бүхий VSEP технологийн VMAT I-36 системийн ажилласан тос цэвэршүүлэх үйлдвэрийн иж бүрэн тоног төхөөрөмжийг худалдан авсан. Энэхүү тоног төхөөрөмжийг Монгол руу тээвэрлэх тээвэрлэлтийн ажлыг “Туушин” ХХК-тай гэрээ хийн шийдвэрлэсэн ч тээвэрлэх хугацаанд Хятад улсад газар хөдлөлт болж, үүнээс үүдэн Хятадын галт тэрэгний ачаалал ихсэн үйлдвэрийн тоног төхөөрөмж Хятад улсын Тяанжин мужид 4 сар саатсан байна. Уг үйлдвэрийн тоног төхөөрөмж нь 40 тонны 3 контайнероор тээвэрлэгдэж ирсэн. 2008 оны 9 сарын 1-нээс 14-ний хооронд тоног төхөөрөмжөө угсарч туршилтын үйл ажиллагааг эхлүүлсэн.</p>
<p>“БиДиСЕК” ХК-тай 2009 оны 9 сарын 29-ний өдөр байгуулсан хамтын ажиллагааны гэрээ</p>	<p>Энэхүү гэрээгээр “ХайБиОйл” ХК-ийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг хэвийн болгох зорилгоор нийт 545,871,480 төгрөгний нэмэлт санхүүжилт шаардагдаж байсан ч гэрээ байгуулагдсаны дараагаар эрчим хүчний эрсдлийг арилгах зорилгоор цахилгаан генераторын үнэ 38,000,000 төгрөг, валютын ханшийн зөрүү 3,891,070 төгрөг нэмэгдэж нийтдээ 587,762,550 төгрөгний санхүүжилт татахаар болсон.</p> <p>Үүний 67 хувь буюу 388,762,550 төгрөгийг нэмэлт хувьцаа гаргах замаар, үлдэх 33 хувь буюу 199,000,000 төгрөгийг Капитрон банкттай нийт санхүүжилтийн 3/2 хувийг санхүүжүүлсний дараагаар Японы төслийн зээл болох JBC-д хамруулахаар төлөвлөж байна.</p> <p>Нэмж хувьцаа гаргах замаар санхүүжилт татан төвлөрүүлэх нь цаг хугацааны хувьд нилээн хугацаа авдаг учир түүний андеррайтер “БиДиСЕК” ХК-ний зүгээс “ХайБиОйл” ХК-ийн үйлдвэрлэлийг бүтээгдэхүүний борлуулалтын гол үе болох зуравдугаар сараас өмнө ашиглалтанд оруулах зорилгоор нийт татан төвлөрүүлэх 388 сая төгрөгний 74,47 хувь буюу 289,5 сая төгрөгийг “ХайБиОйл” ХК-нд урьдчилан зээлдүүлсэнээр шаардлагатай гэсэн тоног төхөөрөмжүүдийг худалдан авч үйлдвэрлэлийг эхлүүлээд байна.</p>

“DUNWELL GROUP.,LTD” компанитай 2010 оны 3 сарын 19-ны өдөр нэмэлт тоног төхөөрөмж худалдан авах гэрээ	Энэхүү гэрээгээр “ХайБиОйл” ХК-ний үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах VMAT I-36 шүүр, цэвэрлэгээний иж бүрэн төхөөрөмж, лабораторийн багаж зэрэг нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг нийт 120,000 ам.долларын үнийн дүнтэй авахаар болсон. Төлбөрийн нөхцөл нь урьдчилгаа 75 хувь болох 90,000 ам.долларыг төхөөрөмж захиалахад, үлдэх төлбөрийг тээвэрлэсэн тоног төхөөрөмжийг хүлээн авч үйл ажиллагаанд оруулсанаас хойш 6 сарын дараа үлдэгдэл төлбөр болох 30,000 ам.долларыг Данвэллд төлнө. Уг гэрээгээр худалдан авсан тоног төхөөрөмжүүд 2010 оны 5 сарын 14-нд Монгол Улсад орж ирсэн бөгөөд төхөөрөмжийг 22-нд нь угсарч дуусан, ажиллагаанд оруулаад байна.
--	--

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Монголд анх удаа техникийн ажилласан тосыг цэвэршүүлэн эдийн засгийн эргэлтэнд оруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэр байгуулахаар Хонг Конгийн DUNWELL GROUP.,LTD компанийн 1 сард 200 тонн ажилласан тос боловсруулах хүчин чадалтай VSEP технологийн VMAT I-36 системийн ажилласан тос цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг Сонгино хайрхан дүүргийн 20 дугаар хороонд байрлах өөрийн үйлдвэрийн талбайд байгуулахын тулд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах ажлуудад зарцуулсан.

Хүснэгт 1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт /төгрөгөөр/

	Анхны хувьцаагаарх санхүүжилт /2007.4.19 СЗХ 41 тоот тогтоол/	Нэмэлт хувьцаагаарх санхүүжилт /2007.11.29 СЗХ 182 тоот тогтоол/	Зээл
VSEP VMAT I-36	32,620,000.00	507,273,557.00	180,400,000.00
Тээврийн зардал			11,938,050.00
Үйлдвэрийн барилга, хашаа, цахилгаан холболт	168,443,294.00	8,725,287.00	21,000,000.00
Нэмэлт төхөөрөмж		12,334,327.00	49,337,309.00
400 м3 агуулах	63,493,357.00	11,204,710.00	
Тоног төхөөрөмж суурилуулалт, программ хангамж	101,800,000.00		
Компанийн санхүүжилтын зардал	53,200,000.00	34,800,000.00	
Түүхий эд	10,127,534.00	10,127,534.00	10,127,534.00

Тавилга, эд хогшил	33,135,614.00	4,733,659.00	9,467,318.00
Өглөг	5,453,000.00		
Удирдлага	31,851,307.00	31,851,307.00	148,639,435.00
Нийт дүн	500,124,106.00	621,050,381.00	430,909,646.00

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үйлдвэр дээр хийгдсэн ажлууд

1. VSEP технологийн VMAT I-36 системийн тоног төхөөрөмжийг бүрэн угсарч ажиллагаанд оруулсан ба үйлдвэрийн хэвийн үйл ажиллагаанд Dunwell Group-ээс интернет ашиглан хяналт тавих болно. /зураг 1/



2. ХайБиОйл ХК-ийн СХД-т байрлах өөрийн үйлдвэрлэлийн зориулалттай 0,8 га газарт 336 м² үйлдвэрлэлийн зориулалттай барилга барьсан. /зураг 2/



3. Уг үйлдвэрийн байрны дэргэд 400 м³ багтаамжтай цэвэршүүлсэн болон бохир тосны агуулах байгуулсан. /зураг 3/



4. Үйлдвэрлэлд шаардлагатай 630kWt эрчим хүчтэй холбосон. /зураг 4/



5. Үйлдвэрлэлийн зориулалттай газарт 200 м бетонон хашаа хийж гүйцэтгэсэн.
6. 22.5 м² ажилчдын байр
7. 30 м-ийн гүний худаг
8. Цагт 2,5м³ 7Па хүчин чадалтай компрессор
9. Цагт 0,5 м³ уур үүсгэх бойлер

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ БУЮУ НЭМЖ ГАРГАХ ХУВЬЦАА

Одоо үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд бохирдсон шүүр солих, компанид тулгамдаж буй өр төлбөрийг барагдуулах, бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж, ашиг орлогыг нэмэгдүүлэхийн тулд бүтээгдэхүүний өнгө сайжруулах шинэ тоног төхөөрөмж авах, үйлдвэрийн хэвийн үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт тоног төхөөрөмжүүдийг авахад нийт 587 сая төгрөгний санхүүжилт шаардагдаж байсан.

Хүснэгт 2. Нэмэлт санхүүжилтийн задаргаа

	Зарцуулалт	мян.төг	%
1	VSEP - VMAT I-36 шүүр	113,680.00	19.34%
2	Тээврийн зардал	9,463.86	1.61%
3	Мэргэжилтэний зардал	37,931.03	6.45%
4	Лабораторийн тестийн багаж	2,131.50	0.36%
5	Өнгө сайжруулагч	170,520.00	29.01%
6	Генератор	38,082.80	6.48%
7	Тоног төхөөрөмжийн даатгал	5,160.01	0.88%
8	Өр төлбөр	157,360.40	26.77%
9	Дахин санхүүжилтын зардал	53,432.96	9.09%
	Нийт дүн	587,762.55	100.00%

“ХайБиОйл” ХК нь брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх “БиДиСЕК” ХК-тай дээрхи санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр 2009 оны 9 сарын 29-ний өдөр нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 10 хувийн үнийн дүнтэй тэнцэх ажлын хөлстэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн.

Дээрх хамтын ажиллагааны гэрээний үндсэн нөхцлүүдийг компанийн 2009 оны 11 сарын 17-ны ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан нэмж санхүүжилт татан төвлөрүүлэхийг 1 тоот тогтоолоор батлан, энэхүү ажлыг хувь нийлүүлэгчдийн хурлын 2 тоот тогтоолын дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлд хариуцуулан өгсөн билээ.

“БиДиСЕК” ХК-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 67 хувь буюу 388,762,550 төгрөгийг нэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх ба үүнийг 74,47 хувийг хувьцаанд хөрвөх зээл, үлдэх 25,53 хувийг Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны арилжаагаар олон нийтэд санал болгон татан төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Үлдэх 33 хувь буюу 199,000,000 төгрөгийг Капитрон банктай нийт санхүүжилтийн 3/2 хувийг санхүүжүүлсний дараагаар Японы төслийн зээл болох JBIC-д хамруулахаар төлөвлөсөн болно.

Хувьцааны үнэ тогтоосон үндэслэл

СЗХ-ны 2010 оны 8 сарын 25-ны хурлын 234 дугаар тогтоолын дагуу хувьцааны нэг бүрийн үнийг Монголын Хөрөнгийн Биржийн гаргадаг 6 сарын дундаж ханшийг дахин шинэчлэн 174 төгрөгөөр тогтоосон ба тогтоолын 5 дугаар зүйлд заасны дагуу өмнө нь хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид нийт гарах нэмэлт хувьцаанаас өөрийн эзэмшиж байгаа хувьцааны 31,92 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг олгож байна.

Хүснэгт 3. Нэмэлт гаргах хувьцааны задаргаа /төгрөгөөр/

1	Нэмэлт хувьцааны нэг бүрийн худалдах үнэ	174
2	Хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгө	388,762,550
3	Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу /үнийн дүн/	289,520,302
4	Олон нийтэд санал болгох /үнийн дүн/	99,242,248
5	Нийт нэмэлт гаргах хувьцааны тоо	2,234,268
6	Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу /тоо ширхэг/	1,663,910
7	Олон нийтэд санал болгох /тоо ширхэг/	570,358
8	Тэргүүн ээлжинд худалдан авч болох хувь	31.92%

Компанийн нийт гаргасан хувьцаа: 7,000,000 ширхэг

Нэмж гаргах хувьцааны нэг бүрийн үнэ: 174 төгрөг

Нэмж гаргах хувьцааны тоо: 2,234,268 ширхэг

Нэмэлт хувьцаа гарсаны дараах нийт хувьцааны тоо: 9,234,268 ширхэг

Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу олгогдсон мөнгө, түүний зарцуулалт

Хүснэгт 4. Нийт орсон мөнгөн хөрөнгө, хувьцаанд хөрвөх тоо

	Хувьцаанд хөрвөх зээл өгсөн	Үнийн дүн	Хувьцаанд хөрвөх тоо
1	“БиДиСЕК” ХК	257,231,300.00	1,478,341
2	“ЭмИТиЭф” ХХК	32,289,000.00	185,569
	Нийт дүн	289,520,300.00	1,663,910
	Нийт хувьцаагаар гаргах үнийн дүнд эзлэх хувь		74.47%

Хүснэгт 5. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу орсон мөнгөний зарцуулалтын задаргаа /төгрөгөөр/

	Зарцуулалт	Үнийн дүн
1	Хугацаа хэтэрсэн өр төлбөрт	153,731,780.00
2	Үйлдвэрийн бэлтгэл ажилд	15,060,000.00
3	VMAT I-36 шүүлтүүр	85,080,000.00
4	Лабраторийн төхөөрөмж (1 ком)	1,595,250.00

5	Цэвэрлэгээний төхөөрөмж (Clean In Place system)	20,206,500.00
6	Цэвэрлэгээний химийн бодис	4,254,000.00
7	Мэргэжилтэнгийн зардал	4,785,750.00
8	Нисэх онгоцны зардал	4,807,020.00
	Нийт дүн	289,520,300.00

Нэмэлт санхүүжилт хийгдсэнээр

Дээрхи санхүүжилт хийгдсэнээр “ХайБиОйл” ХК-нд тулгараад байсан зайлшгүй төлөх өр төлбөрийг барагдуулж, үйлдвэрлэлийг хэвийн үйл ажиллагаанд шаардагдах VMAT I-36 шүүр болон бусад нэмэлт тоног төхөөрөмжүүдийг худалдан авч 2010 оны 5 сарын 14-ны өдөр Монгол улсад оруулан ирж бүрэн угсарсанаар үйлдвэрийн үйл ажиллагаа 2010 оны 5 сарын 22-ноос хэвийн ажиллаж эхэлсэн.

Шинэ шүүрийг 2010 оны 5 сарын 20-нд суурилуулсан. /зураг 5/



Шүүлтүүрийн бохирдлоос хамааран тодорхой давтамжтайгаар угааж цэвэрлэж шүүлтүүрийг бохирдож гацахаас сэргийлэх цэвэрлэгээний төхөөрөмжийг 2010 оны 5 сарын 19-нд угсарж дууссан. /зураг 6/



Шинээр ирсэн лабораторийн багаж нь үйлдвэр дээр ирсэн бүх тосонд хяналт тавьж бохирдсон тосны техникийн үзүүлэлтүүдийг бүрэн шинжилж, үйлдвэрийн тоног төхөөрөмжинд оруулан цэвэрлэгээ хийж болох эсэх, оруулбал ямар цэвэрлэгээг түлхүү хийхийг тогтооно. /зураг 7/



Шинээр ирсэн вакум насос нь тосыг механик хог хаягдлаас ялгасны дараагаар тосыг вакум орчинд халааж усны нэгдлээс ялгах, ингэснээр тосны техник үзүүлэлтүүдийг сайжруулах юм. /зураг 8/



Тоног төхөөрөмж нийлүүлэгч талаас мэргэжилтэнүүд ирж сургалтуудыг зохион байгуулж байна. Нэмэлт санхүүжилт орж VMAT I36 шүүлтүүрийг худалдан авч суурилуулан, ажилчдад 14 хоногийн сургалтыг үйлдвэрийн тоног төхөөрөмжин дээр нь зохион байгууллаа. /зураг 9/



ТӨСЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

“БиДиСЕК” ХК-тай 2009 оны 9 сарын 29-ны өдөр байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд “ХайБиОйл” ХК-нд нийт 289’520’302 төгрөгний санхүүжилт хийгдэж (хүснэгт 5) компанийн шаардлагатай өр төлбөрийг барагдуулж, үйлдвэрлэлд нэн тэргүүнд шаардагдаж буй тоног төхөөрөмж болох VMAT I-36 шүүлтүүр, шүүлтүүрийн цэвэрлэгээний төхөөрөмж, тосны лабораторийн багаж, вакум насос зэргийг худалдан авч 2010 оны 5 сарын 14-нд Монголд авчиран бүрэн угсаргаанд оруулан үйлдвэрлэлийг хэвийн ажиллагаанд оруулаад байна.

Ингэснээр үйлдвэрлэлээс гарах бүтээгдэхүүний хэмжээ жигдэрч, борлуулалт хийх бүрэн боломжтой болоод байгаа ба гарсан бүтээгдэхүүнийг эхнээс нь Да Хүрээ техникийн зах, зам барилгын компаниудад борлуулж эхлээд байна.

Дээрх санхүүжилтийн цаана үлдэж буй санхүүжилтаар бид бүтээгдэхүүний чанарыг шинэ түвшинд гаргах өнгө сайжруулагч тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн цахилгаан эрчим хүчний нөөц хангамжийг бий болгох зорилгоор цахилгаан үүсгүүр, одоо худалдан аваад буй тоног төхөөрөмжийн үлдэгдэл 25 хувийн төлбөр зэргийг барагдуулах болно.

Бүтээгдэхүүний өнгийг сайжруулан зах зээлд гаргаснаар одоогийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, өндөр үнээр борлуулах боломж бүрдэх юм.

Сонирхолын зөрчилтэй хэлцэл

“ХайБиОйл” ХК-ийн андеррайтераар ажиллаж буй “БиДиСЕК” ХК нь уг компанийн 8,25 хувийг эзэмшдэг бөгөөд уг 2 компанийн хооронд байгуулсан гэрээ нь Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасны дагуу сонирхолын зөрчилтэй хэлцэл болж байна.

Тиймээс уг сонирхолын зөрчилтэй хэлцлийг компанийн тухай хуулийн 89.1, 89.3, 89.4 дүгээр зүйлд заасны дагуу “ХайБиОйл” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Хувь нийлүүлэгчдийн хурлаар хараат бус гишүүд, болон хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэсэн.

ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

Түүхий эд болох ажилласан тосыг худалдан авах үнэ нь зах зээл дээр харилцан адилгүй үнэтэй байдаг ба өнөөдрийн байдлаар Монголд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн томоохон компаниудаас зөвхөн тээвэрлэлтийн зардлаар нь авч байна. Энэ нь 150-200 төгрөг орчим болох болно. Одоо худалдан авч буй дундаж ханш нь 189,76 төгрөг болж байгаа бөгөөд энэ үед бүтээгдэхүүний өртөг 620.42 төгрөг болж байгаа юм.

Хүснэгт 6. Бүтээгдэхүүний өртөг

Зардал	Нэгж	Хэмжээ.сар	Үнэ	Дүн, сараар	%
Түүхий эдийн зардал	тн	180.00	189.76	34,156,800.00	61.17%
Тээврийн зардал	тн	90.00	100,000.00	9,000,000.00	16.12%
Сав баглаа боодол	ширхэг		1.00	7,875.00	0.01%
Түлш шатахуун	литр	1.00	567,677.50	567,677.50	1.02%
Шатах тослох материал	төгрөг			134,377.50	0.24%
Эрчим хүчний зардал	квт			7,094,318.40	12.71%
Цалин	хүн		2,890,000.00	2,890,000.00	5.18%

НДШ	хүн		317,900.00	317,900.00	0.57%
ХХАА, хоол хүнс	хүн	11*30*3000	990,000.00	990,000.00	1.77%
Интернет	төгрөг			587,300.00	1.05%
Газар ашиглалтын төлбөр	төгрөг			92,000.00	0.16%
Нийт дүн	төгрөг			55,838,248.40	100.00%
Бүтээгдэхүүний хэмжээ.сараар		Бүт.өртөг	Борлуулах үнэ		
Гидрийн шигэн	90,000.00	620.42	1,500.00		

Бүтээгдэхүүний зах зээл

Манай орны хурдацтай хөгжиж буй салбар болох уул уурхайн салбар нь бидний бүтээгдэхүүний гол зах зээл байх болно. Учир нь бидний үйлдвэрлэн гаргах энэхүү бүтээгдэхүүн нь олон улсад итгэмжлэгдсэн “Saybolt” /АМБЕР/ лаборатори, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын шинжилгээний хариугаар баталгаажиж, гидрийн шингэн, үйлдвэрийн тос, суурь тос, мазутаар ашиглах боломжтой болсон.

Эдгээр бүтээгдэхүүнүүдээс зах зээлд хамгийн эрэлттэй, өндөр үнээр зарагддаг бүтээгдэхүүн нь гидрийн шингэн бөгөөд гидрийн шингэний хэрэглээний 80 хувь нь уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт байна. Мөн бид өөрийн бүтээгдэхүүнээ уул уурхайн болон хүнд үйлдвэрүүдэд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тосолгооны зорилгоор, цахилгаан станцуудад шаталтыг дэмжих мазут хэлбэрээр нийлүүлэх бүрэн боломжтой.

Манай компаний ажилласан тос боловсруулах үйлдвэр нь хаягдал тосны 25%-ийг боловсруулан гидрийн шингэн, үйлдвэрийн тосны зах зээлийн 16%-аас багагүйг хангах бөгөөд цаашид үйлдвэрийн хүчин чадалыг нэмэгдүүлж, зах зээлд эзлэх байр сууриа өсгөх боломжтой.

Хүснэгт 7. Мөнгөн урсгалын төсөөлөл

		10P*	11P*	12P*	13P*	14P*
1	Борлуулалтын орлого	810,000,000	1,620,000,000	1,620,000,000	1,620,000,000	1,620,000,000
2	Ү/а-ны зардал	444,776,528	803,671,456	695,671,456	695,671,456	695,671,456
3	Ү/а-ны ашиг	365,223,472	816,328,544	924,328,544	924,328,544	924,328,544
4	Дахин санхүүжилтын зардал	56,326,929	0	0	0	0
5	Татварын өмнөх ашиг	308,896,542	816,328,544	924,328,544	924,328,544	924,328,544
6	Татвар	30,889,654	81,632,854	92,432,854	92,432,854	92,432,854
7	Татварын дараах ашиг	278,006,888	734,695,689	831,895,689	831,895,689	831,895,689
8	Нийт гаргасан хувьцаа *	9,591,750	9,591,750	9,591,750	9,591,750	9,591,750
9	Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ	2,139,846,550	2,139,846,550	2,139,846,550	2,139,846,550	2,139,846,550
10	EPS	28.98	76.59	86.73	86.73	86.73
11	ROE	12.99%	34.33%	38.87%	38.87%	38.87%


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2009 оны 11 сарын 17-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын өмнөх тархалтын дагуу компанийн нийт хувьцаа 7,000,000 ширхэг бөгөөд нийт 241 хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 8. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэмшдэг этгээдийн талаархи мэдээлэл:

	Нэр	Иргэн бол эрхлэдэг ажил, хуулийн этгээд бол байршил	Эзэмшиж буй хувьцааны %
1	Өлзийсайхан Хүдрээ	“ХайБиОйл” ХК Гүйцэтгэх захирал	13,84%
2	Firebird Global Master fund II Ltd	c/o Trident Trust (Cayman) Services, Ltd., One Capital Place, P.O. Box 847 GT, George Town, Grand Cayman, Cayman Islands	28,29%
3	БиДиСЕК ХК	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1	8,25%
4	Mongolia Capital Limited	Strathvale House, 90 North Church Street, P.O. Box 2636 Grand Cayman, KY1-1102, Cayman Islands	12,71%

Хувьцааны арилжааны талаарх мэдээлэл



Хүснэгт 9. Арилжааны мэдээ /жилээр/

Он	Арилжигдсан ширхэг	Хувьцааны ханш /төгрөгөөр/		
		Дээд	Доод	Хаалт
2007	4,299,052.00	450.00	100.00	315.00
2008	4,004,962.00	400.00	200.00	267.00
2009	1,207,238.00	267.00	134.00	200.00
2010.6	637,641.00	241.00	160.00	195.00

Эрсдэл

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд гадаад, дотоод гэсэн 2 үндсэн шалтгаанаас улбаалж доголдол гарах эрсдэл бий.

Хүснэгт 10. Эрсдлийн хүчин зүйлүүд

	Дотоод хүчин зүйл	Гадаад хүчин зүйл
1	Эрчим хүчний тасралт	Нефтийн бүтээгдэхүүний үнэ
2	Чанаргүй түүхий эд	Бүтээгдэхүүний хэрэглээ
3	Боловсон хүчний туршлага	Тоног төхөөрөмжийн сэлбэг
4	Бүтээгдэхүүний чанар	Цаг уурын байдал
5	Шүүлтүүр	

Дотоод хүчин зүйл: “ХайБиОйл” ХК-ийн ажилласан тос дахин боловсруулах үйлдвэрийн дотоод хүчин зүйлээс хамаарах эрсдлүүд нь технологийн горим, боловсон хүчнээс шууд хамаарах эрсдлүүд юм.

Эрчим хүчний тасралт. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд учирч болох гол эрсдэл нь эрчим хүчний асуудал байна. Учир нь үйлдвэр ажиллаж байх хугацаанд төхөөрөмжинд маш их хэмжээний бохир тос эргэлдэж байдаг ба энэ үед нь эрчим хүч тасалдвал төхөөрөмжинд байсан тос зарцаж, улмаар төхөөрөмжийн эд ангиудыг гацаах эрсдэлтэй юм. Бид 2008 оны 10 сард үйлдвэрлэлээ эхлэхдээ яг ийм эрсдэлтэй тулгарч байсан бөгөөд үүнээс үүдэн шүүлтүүр бохирдон эвдэрсэн. Бид энэхүү эрсдлийг багасгахын тулд цахилгаан генератор худалдан авч үйлдвэр дээрээ байрлуулах ба ингэснээр эрчим хүч тасарсан үед төхөөрөмжийг ажлуулан цэвэрлэгээ хийн аюулгүйжүүлэх юм. Мөн бид эрчим хүчийг төмөр замын эрчим хүчнээс авдаг бөгөөд эрчим хүчний төлбөрийг цаг тухай бүр нь төлөн ажиллаж байна.

Чанаргүй түүхий эд. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжинд чанаргүй тос хийх нь тоног төхөөрөмжийн эд ангид муугаар нөлөөлж төхөөрөмжийг эвдэж болзошгүй. Тухайлбал хог хаягдал ихтэй, хэт бохир тос орсоноор механик хог хаягдлыг ялгагч центрфук-ийг гэмтээх, цаашилбал шүүлтүүрийг бөглөх аюултай. Тиймээс бид үйлдвэрлэлдээ **лабораторийн багаж** ашиглаж эхэлсэн. Энэ нь үйлдвэр дээр ирсэн бүх тосонд хяналт тавьж бохирдсон тосны техникийн үзүүлэлтүүдийг бүрэн шинжилж, үйлдвэрийн тоног төхөөрөмжинд оруулан цэвэрлэгээ хийж болох эсэх,

оруулбал ямар цэвэрлэгээг түлхүү хийхийг тогтоох юм. Энэ нь шүүлтүүрт хэт бохир тос оруулан, үйлдвэрийн үйл ажиллагааг гацаахгүй байх үндсэн хамгаалалт байх болно. Мөн **цэвэрлэгээний төхөөрөмжийн иж бүрдэл** суурилуулсан. Өмнө нь шүүлтүүр эдвэрсэн гол шалтгаан нь үйлдвэрийн эрчим хүч тасалдаж, улмаар шүүлтүүрийн доторхи эд ангийг цэвэрлэж чадахгүй байснаар шүүлтүүрийн доторхи тос угжирч, лагширан шүүлтүүрийг гацаасан. Харин энэхүү нэмэлт цэвэрлэгээний төхөөрөмж нь шүүлтүүрийн бохирдлоос хамааран тодорхой давтамжтайгаар угааж цэвэрлэж байх зориулалттай учир шүүлтүүрийг бохирдож гацахаас сэргийлэх болно. **Вакум насос** нь тосыг механик хог хаягдлаас ялгасны дараагаар тосыг вакум орчинд халааж усны нэгдлээс ялгах, ингэснээр тосны техник үзүүлэлтүүдийг сайжруулах юм.

Боловсон хүчний туршлага. “ХайБиОйл” ХК-ний удирдлага нь хэдийгээр нефтийн бүтээгдэхүүний салбарт арав гаруй жил ажилласан дадлага туршлагатай ч энэхүү тоног төхөөрөмж нь бидний хувьд цоо шинэ технологи юм. Бүрэн автомажсан, шинэ төрлийн шүүлтүүр гэх мэт. Энэхүү үйлдвэр нь байгуулагдаад бараг 2 жил болох гэж байгаа ба энэ хугацаанд үйлдвэрийн ажилчид үйлдвэрийн тоног төхөөрөмжтэйгээ хангалттай танилцан судалсан. Мөн үйлдвэрийн дарга, компанийн гүйцэтгэх захирал нь энэ тоног төхөөрөмжин дээр ажиллах дадлагыг Хонг Конг-д очиж хийсэн. Мөн Данвеллийн мэргэжилтэнгүүд 2 удаа ирж үйлдвэрийн ажилчдад сургалт зохион байгуулсанаар боловсон хүчний зүгээс гарах эрсдлийг бууруулсан юм.

Бүтээгдэхүүний чанар. Бидний үйлдвэрлэн гаргах бүтээгдэхүүн нь Монгол улсын болон бусад улс орнуудын чанарын шаардлагыг хангаж байгаа эсэх нь бидний хамгийн гол асуудал юм. Учир нь бид бүтээгдэхүүнээ борлуулахдаа өөрийн бүтээгдэхүүний чанарт үндэслэн үнэ тогтоон борлуулах юм. Тиймээс ч бид өөрсдийн бүтээгдэхүүнийг 3 сар тутам олон улсад итгэмжлэгдсэн лаборатори болох “Амбер”-аар шинжлүүлэн мазут, гидрийн шингэн, үйлдвэрийн тосны шаардлагыг хангаад байгаа. Гэвч бидний үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүний өнгө нь хар бараан өнгөтэй байгаа нь хэрэглэгчдийн сэтгэлд төдийлөн нийцэхгүй байх хандлага байна. Тиймээс бид энэ эргэлзээг арилгах үүднээс өнгө сайжруулагч төхөөрөмж худалдан авах төлөвлөгөөтэй байна.

Шүүлтүүр. VMAT I-36 шүүлтүүр нь тосны бохирдолын зэргээс хамааран ажиллах хугацаа нь 1-2 жил байдаг байна. Бид дээрх арга хэмжээнүүдийг авсанаар шүүлтүүрийн насыг уртасгах боломжтой болох юм. Мөн энэхүү шүүлтүүрийн үнэ нь бүтээгдэхүүний өртөгт сууж өгсөн байгаа тул 1 жил ажилаад шинэ шүүлтүүрийг авч байхаар эдийн засгийн тооцооллыг хийсэн байгаа.

Гадаад хүчин зүйлийн эрсдэл: Энэ эрсдэл нь “ХайБиОйл” ХК-ийн үйл ажиллагаанаас хамаарахгүйгээр учирч болох эрсдэл юм.

Нефтийн бүтээгдэхүүний үнэ: Манай улс нь энэ төрлийн бүтээгдэхүүн дээр 100 хувь гадаад улс орноос хараат учир Монголд энэ төрлийн бүтээгдэхүүний үнэ буурах магадлал маш бага юм.

Бүтээгдэхүүний хэрэглээ: Бидний үйлдвэрлэн гаргадаг бүтээгдэхүүн нь үндсэн 4 төрлийн физик шинж чанарыг хангаж байгаа ба хамгийн өндөр хэрэглээтэй нь мазут юм. Гэвч сүүлийн жилүүдэд мазут ашигладаг үйлдвэрүүдийн тоо багассаар байгаа нь энэ төрлийн зах зээл хумигдаж болзошгүй юм. Гэвч эсрэгээр Монгол Улсад сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын өсөлт маш хурдтай явагдаж байгаа гидрийн шингэний зах зээлийг өсөн нэмэгдүүлэх сайн талтай.

Тоног төхөөрөмжийн сэлбэг: Бид өөрсдийн тоног төхөөрөмжийг Хонг Конгийн Данвелль группээс авсан бөгөөд уг тоног төхөөрөмжинд зөвхөн Данвеллийн л сэлбэг таардаг юм. Энэ нь хэрэв Данвеллийн үйл ажиллагаа доголдож, үйл ажиллагаагаа явуулахаа зогсоовол үйлдвэрт сэлбэг нийлүүлэх газаргүй болох эрсдэлтэй юм. Тиймээс бид энэ талыг бодолцон тоног төхөөрөмж худалдан авах гэрээнд 5 жилийн хугацаанд шаардлагатай сэлбэгийг нийлүүлэх заалт оруулж өгсөн.

Цаг уурын байдал: Манай орны цаг уурын байдал нь эрс тэс учир үйлдвэрийн тоног төхөөрөмжийг царцаах, шороо тоос орон бохирдуулах эрсдэл бий. Мөн энэхүү тоног төхөөрөмж нь манай орны өвөл шиг хүйтэн нөхцөлд туршигдаж байгаагүй юм. Тиймээс бид үйлдвэрийг тоног төхөөрөмжүүдийг зориулалтын байшинд суурилуулж дээрх эрсдлийг бууруулахаар ажиллаж байна.

ХУВЬЦАА ХЭРХЭН ХУДАЛДАН АВАХ

“ХайБиОйл” ХК-ны хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдаж буй 388 сая төгрөгний санхүүжилтэнд зориулж 174 төгрөгний нэрлэсэн үнэтэй 2,234,268 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж байна.

Нэмж гаргаж буй энгийн хувьцааг доорхи байдлаар нийтэд санал болгож байна.

- “БиДиСек” ХК, “ЭмИТиЭф” ХХК-ийн хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу оруулсан нийт 289,520,300 төгрөгийн зээлийг нэг бүр нь 174 төгрөгийн үнэтэй 1,663,910 ширхэг хувьцаанд хөрвүүлэх
- Нийтэд нээлттэй худалдагдах 570,358 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 174 төгрөгөөр нийтэд худалдах

	Ажлын дараалал	Хугацаа
1	Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр	2010 оны 8 сарын 25-ны 234 тоот тогтоол
2	Монголын хөрөнгийн биржийн шийдвэр гарах	Ажлын 30 хоног
3	Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх хугацаа	2010 оны 8 сарын 25-ны өдрөөс 2010 оны 10 сарын 6-ны өдрийг дуустал ажлын 30 хоног
4	МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаа	Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх ажлын 30 хоногийн хугацаа дууссаны дараа

2009 оны 10 сарын 6-нд гаргасан тархалтаар буюу 2009 оны 11 сарын 17-ны ээлжит бус хурлын бүртгэх өдрөөр хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 35.1.4 болон 39 дүгээр зүйлд заасны дагуу нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас өөрийн эзэмшиж буй хувьцааны 31,92 хувьтай тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

- Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхдээ харьяа брокер, дилерийн компанидаа захиалга өгч, хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх мэдэгдэл, хувьцааны үнийг төлсөн баримтын хамт “ХайБиОйл” ХК-д ирүүлнэ.
- Тэргүүн ээлжинд худалдан авах хувьцааны арилжаа хоёрдогч зах зээлийн арилжаанаас тусдаа зохион байгуулагдана.
- Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх талаар мэдэгдээгүй нөхцөлд тухайн хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсанд тооцож, хувьцааг МХБ-ээр нийтэд санал болгон худалдан борлуулна.
- Нэмэлт хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээг: Харилцагч нар өөрийн харьяа брокер, дилерийн компаниуд болон Хөрөнгө оруулалтын зөвлөх,

Андеррайтер, Брокер, Дилерийн БиДиСек ХК-аас мөн www.bdsec.mn, www.hboil.mn сайтуудаас авч болно.

АНДЕРРАЙТЕР

“БиДиСЕК” ХК нь 1995 онд байгуулагдсан бөгөөд хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 15 жил үйл ажиллагаа явуулж буй андеррайтер, брокер, дилер хөрөнгө оруулалтын зөвлөхийн компани юм. Манай компани 2006 оны 6-р сард зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн олон нийтэд өөрийн хувьцааг санал болгон арилжаалан хөрөнгийн зах зээл дээрээс 1 тэрбум төгрөг, 2008 онд нэмэлт хувьцаа гаргаснаар хөрөнгийн зах зээлээс нийт 3.7 тэрбум төгрөгийг хөрөнгийг татан төвлөрүүлж үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн ажиллаж байна.

Манай компани нь Андеррайтерийн үйлчилгээ үзүүлдэг ууган компаниудын нэг бөгөөд 2005 оны 6-р сарын 07-ны өдрийн 34 тоот тогтоолоор Андеррайтерийн үйлчилгээ эрхэлэх тусгай зөвшөөрөл авсан юм. Монголын Хөрөнгийн зах зээл дээр 2005-2008 онд нийт 13 компани шинээр үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн бөгөөд “БиДиСЕК” ХК нь 8 хувьцаат компанийн Андеррайтераар ажилласан.

Мөн 2004, 2005 онд “Пума групп”-ийн Пума бонд, 2005 онд “Монинжбар” ХК-ийн “Бүтээн байгуулалт бонд”, 2007 онд “Нийслэл өргөө” ХК-ийн “Нийслэл өргөө бонд”-ын ерөнхий зуучлан борлуулагч, 2004 онд “МСиЭС электроникс” ХХК-ийн “МСиЭС электроникс бонд”-ын туслан гүйцэтгэгчээр тус тус ажилласан дадлага туршлагатай.



Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
“БиДиСЕК” ХК
Брокер, Дилер, Андеррайтер,
Хөрөнгө Оруулалтын зөвлөх
www.bdsec.mn



Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
“БИ ДИ СЕК” ХК

Андеррайтер, брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх

Монгол улс, Улаанбаатар хот,
 Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
 Залуучуудын өргөн чөлөө-27/1

Утас: 313108

Факс: 321763

www.bdsec.mn

Огноо 2010.09.06

Дугаар 257

Санхүүгийн Зохицуулах Хороо-нд

Андеррайтерын дүгнэлт

Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх “БиДиСЕК” ХК нь “ХайБиОйл” ХК-ийн ажилласан тос цэвэршүүлэх үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай нэмэлт санхүүжилт болох нийт 587,762,550 төгрөгийг татан төвлөрүүлэхээр 2009 оны 9 сарын 29-ний өдөр хамтын ажиллагааны гэрээ байгуулсны дагуу компанийн өнөөгийн үйл ажиллагаа, удирдлагын туршлага, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, компанийн засаглал, үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө нь төлөвлөж буй төслийн санхүүжилтэнд хүрэх эсэх, компанид учирч болох эрсдэл, болон бусад холбогдох баримт, материалуудыг хянан үзэж хөрөнгийн зах зээлд нийт гаргасан хувьцааных нь 31,92 хувьтай тэнцэх хэмжээний 2,234,268 ширхэг нэмэлт хувьцаа гаргах бүрдүүлбэрийг гүйцэтгэж 2010 оны 8 сарын 25-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 234 тоот тогтоол гарсан.

Компанийн өнөөгийн үйл ажиллагаа, цаашдын чиг хандлага

“БиДиСЕК” ХК нь 2007 онд “ХайБиОйл” ХК-тай хамтран ажиллаж 7,000,000 сая ширхэг үнэт цаас гарган нийт 1,1 тэрбум төгрөгний санхүүжилтийг 2 үе шаттайгаар татан төвлөрүүлж өгсөн билээ. Энэхүү татан төвлөрүүлсэн хөрөнгөөр “ХайБиОйл” ХК нь ажилласан тос цэвэршүүлэх үйлдвэрийг Монголд анх удаа барьж байгуулсан. Гэвч уг үйлдвэр нь 2008 оны 9 сард ашиглалтанд орсноосоо хойш нэг сар ажиллаад эрчим хүчний тасалдлаас үүдэн VMAT I-36 шүүлтүүр нь эдвэрч үйлдвэр ажиллах боломжгүй болжээ. “ХайБиОйл” ХК-ний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь 2008 оны 10 сараас хойш явагдаагүй бөгөөд 2009 оны 9 сарыг хүртлэх нэг жилийн хугацаанд бүтээгдэхүүн гарахгүй, үйлдвэрлэл бүрэн зогссон ба энэ хугацаанд компани ямар ч орлогогүй алдагдалтай ажиллаж ирсэн байна.

“ХайБиОйл” ХК-ийн үйлдвэрлэл хэвийн явах тохиолдолд үйлдвэрлэлээс сард 90 тонн цэвэршүүлсэн тос гарах ба энэ нь И-20 төрлийн гидрийн шингэн, М-100 маркийн мазут түлш, үйлдвэрийн болон суурь тосны чанарын шаардлагыг хангах тул уг бүтээгдэхүүн нь зах зээлд дээрх 4 төрлөөр нийлүүлэгдэх боломжтой.

"ХайБиОйл" ХК нь бидэнтэй 2009 оны 9 сарын 29-нд дахин хамтын ажиллагааны гэрээ байгуулсаны дагуу нийт 289,5 сая төгрөгийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмжийг худалдан авах, хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулахад зориулж "БиДиСЕК" ХК-ийн зүгээс олгоод байна.

Одоо "ХайБиОйл" ХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа чигдэрч эхэлсэн байгаа нь уг компани цаашид үр өгөөжтэй ажиллах нөхцөл бүрдэж, компанийн зорилтот ашгийн түвшинд хүрэх боломжтой болж байна.

Гүйцэтгэх удирдлагын чадвар

"ХайБиОйл" ХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Хүдрээ болон үйлдвэр хариуцсан захирал Б.Мөнхдорж нь нефтийн салбарт 10 гаруй жил ажилласан дадлага туршлагатай байна. "ХайБиОйл" ХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Хүдрээтэй 2009 оны 5 дугаар сарын 8-ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар гэрээ байгуулан ажилласан бөгөөд гэрээ байгуулсанаас хойш хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал, ээлжит хурал, ТУЗ-ийн хурлыг тус тус зохион байгуулан компанийн үйл ажиллагааг өдгөө хэвийн удирдан зохион байгуулж байгаа учир компанийг удирдах тохиромжтой этгээд гэж үзэж байгаа болно.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, компанийн засаглал

Нэмэлт хувьцаа гаргах тухай шийдвэрийг 2009 оны 11 сарын 17-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 1 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн зүгээс батлан гаргасан бөгөөд уг хурлын бүртгэх өдөр болох 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр нийт 241 хувьцаа эзэмшигчид байлаа. Үүнээс 1 хувиас дээш хувьцаа эзэмшдэг 12 хувьцаа эзэмшигч байна.

Хүснэгт 1. 1 хувиас дээш хувьцаа эзэмшдэг этгээдүүд

№	Нэр	Хувьцааны тоо	Эзлэх хувь
1	Д.Даянбилгүүн	74,243	1.06
2	Б.Лхагвадорж	102,500	1.46
3	"ЭМИТиЭф" ХХК	125,555	1.79
4	Дисковери Фанд	127,870	1.82
5	Б.Ариунжаргал	278,101	3.97
6	С.Дарьдулам	289,335	4.13
7	Звахр Александр	322,184	4.60
8	Мастер Фанд	330,000	4.71
9	"БиДиСЕК" ХК	523,711	7.48
10	Монголиа капитал	890,000	12.71

11	Ө.Хүдрээ	968,601	13.83
12	Мастер Фанд II	1,980,000	28.28
	Нийт	6,012,100	85.88

Нэмэлт санхүүжилт татах асуудлыг 2009 оны 11 сарын 17-ны ээлжит бус хурлаар дээрх хувьцаа эзэмшигчид нь санал нэгтгэйгээр батлан гаргасан нь Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаасны бүрдүүлбэр өгөх үндэслэл болсон юм.

“ХайБиОйл” ХК нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, компанийн мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд ил тод байх зорилгоор өөрсдийн дотооддоо мөрдөн хэвшүүлэх дараах журмуудыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2010 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 3, 4, 5, 6, 7 тоот тогтоолуудаар батлан ажиллаж байна.

ТУЗ-аас батлан гаргасан журмууд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам
- Дотоод хяналтын үйл ажиллагааны журам
- Мэдээллийн үйл ажиллагааны журам
- Ногдол ашгийн журам
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам

Дээрх үйл ажиллагааны дагуу тус компани нь жил бүр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тогтмол зарлан хуралдуулж хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр ханган ажиллаж байгаа нь компанийн засаглал сайжирч буй компани хэмээн дүгнэж байна.

Татан төвлөрүүлж буй хөрөнгө

Хүснэгт 2. Нэмэлт санхүүжилтийн задаргаа /Үнэт цаас гаргах бүрдүүлбэр, хуудас 211/

	Зарцуулалт	Мян.төг	%
1	VSEP - VMAT I-36 шүүр	113,680.00	19.34%
2	Тээврийн зардал	9,463.86	1.61%
3	Мэргэжилтэний зардал	37,931.03	6.45%
4	Лабораторийн тестийн багаж	2,131.50	0.36%
5	Өнгө сайжруулагч	170,520.00	29.01%
6	Генератор	38,082.80	6.48%
7	Тоног төхөөрөмжийн даатгал	5,160.01	0.88%
8	Өр төлбөр	157,360.40	26.77%
9	Дахин санхүүжилтын зардал	53,432.96	9.09%
	Нийт дүн	587,762.55	100.00%

“ХайБиОйл” ХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь 2009 оны 9 сарын 29-нд байгуулсан гэрээний дагуу 289,5 сая төгрөгний санхүүжилт хийгдсэнээр 2010 оны 5 сараас жигдэрсэн. Энэхүү санхүүжилтээр үйлдвэрийн үйл ажиллагаанд хэвийн болгоход шаардагдаж байсан бүх тоног төхөөрөмж, хугацаа хэтэрсэн өр төлбөр зэргийг барагдуулсан. Одоо компанид уг төслийг амжилттай хэрэгжүүлэхэд нийт 99,2 сая төгрөгний санхүүжилт шаардагдаж байгаа ба уг санхүүжилт орсоноор тоног төхөөрөмжийн даатгал, түүхий эд, дахин санхүүжилтийн зардал зэрэгт зарцуулагдах ба нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө нь компанийг ашигт ажиллагаанд хүргэхэд хүрнэ гэж андеррайтерын зүгээс дүгнэж байна.

Учирч болох эрсдэл

Үйлдвэр, компанийн үйл ажиллагаанд гадаад, дотоод гэсэн 2 үндсэн шалтгаанаас улбаалж доголдол гарах эрсдэл бий.

Хүснэгт 3. Эрсдлийн гадаад хүчин зүйл

1	Нефтийн бүтээгдэхүүний үнэ	Ижил төрлийн бүтээгдэхүүний үнийн бууралт, үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулах үнэд хэрхэн нөлөө үзүүлэх
2	Бүтээгдэхүүний хэрэглээ	Бүтээгдэхүүний зах зээл, хэрэглэгчид
3	Тоног төхөөрөмжийн сэлбэг	Үйлдвэрийн тоног төхөөрөмж эвдэрэхэд солих эд анги, сэлбэгийн олдоц
4	Цаг уурын байдал	Манай орны цаг уурын нөхцөлд үйлдвэр нь хэр тохиромжтой эсэх

Хүснэгт 4. Эрсдлийн дотоод хүчин зүйл

1	Эрчим хүчний тасралт	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд учирч болох гол эрсдэл нь эрчим хүчний асуудал байна. Учир нь үйлдвэр ажиллаж байх хугацаанд төхөөрөмжинд маш их хэмжээний бохир тос эргэлдэж байдаг ба энэ үед нь эрчим хүч тасалдвал төхөөрөмжинд байсан тос зарцаж, улмаар төхөөрөмжийн эд ангиудыг гацаах эрсдэлтэй юм.
2	Чанаргүй түүхий эд	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжинд чанаргүй тос хийх нь тоног төхөөрөмжийн эд ангид муугаар нөлөөлж төхөөрөмжийг эвдэж болзошгүй.
3	Боловсон хүчний туршлага	Уг төслийн боловсон хүчин уг үйлдвэрийг ажилуулахад хангалттай туршлагатай эсэх.
4	Бүтээгдэхүүний чанар	Үйлдвэрлэн гаргах бүтээгдэхүүн нь Монгол улсын болон бусад улс орнуудын чанарын шаардлагыг хангаж байгаа эсэх

Бид ажилласан тос цэвэршүүлэх үйлдвэр, компанийн үйл ажиллагаанд дараах эрсдлүүд тулгарч болзошгүй хэмээн үзсэн ба уг эрсдлүүдийг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар нэмэлт гарах үнэт цаасны танилцуулгад дэлгэрэнгүй тусгасан байгаа.

Дээрх учирч болох эрсдлийг даван туулах арга хэлбэр нь тохиолдож болох эрсдлийг бууруулж, компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжтой гэж дүгнэж байна.

Үнэт цаасыг олон нийтэд санал болгох арга хэлбэр

“ХайБиОйл” ХК-ны хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдаж буй 388 сая төгрөгний 289,5 сая төгрөгийг компанийн андеррайтер хувьцаанд хөрвөх зээл байгуулан зээлдүүлсэн байгаа бөгөөд үлдэх 99,2 сая төгрөгийг Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаасны арилжаагаар олон нийтэд санал болгоно.

Ингэхдээ нэгж хувьцааг Санхүүгийн Зохицуулах Хорооны 234 тоот тогтоолоор батласан 174 төгрөгөөр тооцох бөгөөд компанийн 2009 оны 10 сарын 6-ны байдлаар хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид компанийн тухай хуулийн 39-р заалтанд заасны дагуу өөрийн эзэмшиж буй хувьцааны 31,92 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос нэмэлт хувьцаа гаргах зөвшөөрөл гарсаны дараагаар ажлын 30 хоногийн хугацаанд эдлүүлнэ.

Хүснэгт 5. Нэмэлт хувьцаа гарах ажлын дараалал

	Ажлын дараалал	Хугацаа
1	Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр	2010 оны 8 сарын 25-ны 234 тоот тогтоол
2	Монголын хөрөнгийн биржийн шийдвэр гарах	Ажлын 30 хоног
3	Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх хугацаа	2010 оны 8 сарын 25-ны өдрөөс 2010 оны 10 сарын 6-ны өдрийг дуустал ажлын 30 хоног
4	МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаа	Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх ажлын 30 хоногийн хугацаа дууссаны дараа

Хувьцааны арилжааны идэвхи

Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны мэдээгээр 2009 оны 11 сарын 13-ны өдрөөс өмнөх байдлаар нийт арилжаалагдсан хувьцааны ширхэг

5,298,061 байгаа нь 2 жилийн хугацаанд нийт гаргасан хувьцааны 75,68 хувь арилжаалагдсан байна. Энэ нь энэхүү хувьцаа нь зах зээлд хөрвөх чадвар сайтай үнэт цаас болохыг илтгэж байна. /МХБ-ийн 1/90 албан бичиг/

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, нэмэлт үнэт цаас гаргахаар ирүүлсэн баримт бичгүүд нь үнэн зөв, ажилласан тос цэвэршүүлэх үйлдвэрлэлээс гаргах бүтээгдэхүүн нь Монгол Улсын чанарын шаардлагийг хангасан, зах зээлд бодит эрэлттэй, ашиглаж буй тоног төхөөрөмж нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, байгаль орчинд хор хөнөөлгүй, эдийн засгийн үр өгөөж бүхий төсөл хэмээн үзэж, олон нийтэд нэмж үнэт цаас гаргах нь тохиромжтой гэж үзэж байна.

Дүгнэлт гаргасан:

Төслийн албаны ажилтан:  /Ц.Цог/
Тэргүүн Дэд Захирал:  /Б.Лхагвадорж/

“АЗУРИТ АУДИТ” ХХК

Нягтлан бодох бүртгэл, хяналтын итгэмжтэгдсэн байгууллага

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг
Пума 12А байр, 04 тоот
Утас: 9909-8727

“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ийн УДИРДЛАГАД

Бид “ХАЙ БИ ОЙЛ” ХК-ийн 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдлийн тэнцэл, тухайн өдрөөр дуусгавар болгон бэлтгэсэн жилийн Орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэж танилцуулах нь байгууллагын удирдлагын үүрэг болно. Харин бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй.

Цар хүрээ

Бид Аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандартад зааснаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэх ёстой. Бид санхүүгийн тайлангуудыг тест дээр үндэслэн шалгасан бөгөөд удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд, мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг бүхэлд нь үнэлсэн. Бидний гүйцэтгэсэн аудит нь дараах дүгнэлт гаргах үндэслэл болж чадна гэдэгт бид итгэж байна.

Аудиторын дүгнэлт


Бидний дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь “ХАЙ БИ ОЙЛ” ХК-ийн 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо /НББОУСХ/-ноос гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зааврыг дагаж мөрдсөн байна.

ЗАХИРАЛ:

Б.Гантуяа

Б.Гантуяа

2008 оны 02 дүгээр сарын 01-ны өдөр



" Хай Би Ойл " ХХК

2007 оны 12 сарын 31-ний санхүүгийн тайлангийн хураангуй

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд		Дүн /мян.төг/
А.Үлдэгдлийн тэнцэл		
1	Мөнгөн хөрөнгө	7,432.40
2	Авлага	222,783.60
2	Бараа, бэлэн бүтээгдэхүүн	12,869.20
3	Бусад актив	
	Эргэлтийн хөрөнгийн дүн	243,085.20
4	Биет хөрөнгө	229,971.70
5	Биет бус хөрөнгө	
6	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	98,830.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	328,801.70
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	571,886.90
1	Богино хугацаат өглөг	179,870.50
2	Урт хугацаат өглөг	
3	Бусад пассив	
	Пассивийн дүн	179,870.50
3	Ердийн хувьцаа	500,000.00
4	Өмчийн бусад хэсэг	
5	Хуримтлагдсан ашиг	(107,983.60)
	Эзэмшигчийн өмчийн дүн	392,016.40
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	571,886.90
Б.Орлогын тайлан		
1	Цэвэр борлуулалт	37,284.90
2	Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг	36,809.10
	Нийт ашиг	475.80
3	Үйл ажиллагааны зардал	108,459.40
	Үйл ажиллагааны ашиг	(107,983.60)
4	Үйл ажиллагааны бус орлого	
	Үйл ажиллагааны бус зардал	
	Ердийн ажиллагааны ашиг /алдагдал/	(107,983.60)
6	Онцгой шинжтэй орлого	
7	Онцгой шинжтэй зарлага	
	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	(107,983.60)
8	Орлогын татварын зардал	
	Цэвэр ашиг /алдагдал/	(107,983.60)
9	Нэгж хувьцаанд ногдох ашиг /алдагдал/	
В.Өмчийн өөрчлөлтийн тайлан		
1	Эхний үлдэгдэл	1,170.00
2	Нэмэгдсэн	498,830.00
3	Хорогдсон	107,983.60
4	Эцсийн үлдэгдэл	392,016.40
Г.Мөнгөн гүйлгээний тайлан		
1	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(235,465.70)
2	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(196,447.50)
3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	439,144.90
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,231.70

"Азурит аудит" ХХК

178

БАЛАНС


" ХАЙ БИ ОЙЛ " ХК

2007 оны 12 сарын 31 өдөр

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Мөрийн дугаар А	БАЛАНСЫН ЗҮЙЛ Б	Үлдэгдэл	
		1-р сарын 1 1	12-р сарын 31 2
1	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө		
01.01.01	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	200,605.00₮	7,432,429.37₮
01.01.02	Богино хугацаат хөрөнгө оруулалт		
01.01.03	Үнэлгээний хасагдуулга		
01.01.04	Дансны авлага	30,983,703.00₮	222,058,214.00₮
01.01.05	Найдваргүй авлагын хасагдуулга		
01.01.06	Бусад авлага		
01.01.07	Бараа материал		12,869,227.00₮
01.01.08	Мал, амьтад		
01.01.09	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
01.01.10	НӨАТ авлага	400.00₮	725,381.10₮
	Эргэлтийн хөрөнгийн дүн	31,184,708.00₮	243,085,251.47₮
